



**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**

АКТ

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.01.20 № ҮАГ-ГАГ 01/16

Алданги ногдуулж, төсвийн
орлого болгох тухай.

“Улсын төсвийн хөрөнгөөр 2012 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн”-д аудит хийх явцад БОНХЯ-ны сайдын багцад хамаарагдах Цэвэр агаар сантай 2011 онд гэрээ байгуулж, санхүүжилт авсан “Цахилгаан тээвэр” ХХК нь нийтийн тээврийн үйлчилгээнд цахилгаан болон дизель түлшээр ажилладаг 1499,9 сая төгрөгийн үнэ бүхий 9 ширхэг доубус угсарч нийлүүлэхээр гурвалсан гэрээг хийсэн боловч хугацаа хэтрүүлэн нийлүүлсэн атал 32,997,8 мянган төгрөгийн алданги тооцоогүй зөрчил илрэв.

БОАЖЯ-ны ТНБД Н.Батсуурь, Цэвэр агаарын сангийн гүйцэтгэх захирал Н.Хүрэлсүх, “Цахилгаан тээвэр” ХХК-ийн гүйцэтгэх захирал нарын 2011 оны 10 дугаар сарын 21-ний өдөр байгуулсан гэрээний тусгай нөхцлийн 46-т “Гэрээний гүйцэтгээгүй ажлын үнийн дүнгийн 0,05 хувь” гэж заасныг үндэслэн акт ТОГТООХ нь:

1. “Цахилгаан тээвэр” ХХК нь нийтийн тээврийн үйлчилгээнд цахилгаан болон дизель түлшээр ажилладаг 1499,9 сая төгрөгийн үнэ бүхий 9 ширхэг доубус угсарч нийлүүлэхээр гурвалсан гэрээг хийсэн боловч хугацаа хэтрүүлэн нийлүүлсэн тул гэрээний тусгай нөхцлийн 46 дах заалтыг үндэслэн 32,997,8 мянган төгрөгийн (1499,8 сая төгрөг х 0,05 х 44 хоног) алданги ногдуулж, улсын төсвийн орлого болгох

2. Улсын төсвийн орлого болгох 32,997,8 мянган төгрөгийг Үндэсний аудитын газрын Төв төрийн сан дахь улсын төсвийн орлогын 90000601 тоот дансанд 2013 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн дотор “Цахилгаан тээвэр” ХХК-иар төлүүлж, барагдуулахыг Цэвэр агаар сангийн гүйцэтгэх захирал Н.Хүрэлсүх, нягтлан бодогч М.Хулан нарт хариуцуулан акт тогтоов.

Акт

Тогтоосон
Үндэсний аудитын газрын
ахлах аудитор
Аудитор
Г.Цэдэнбалжир
С.Уянга

Зөвшөөрсөн
Цэвэр агаарын сангийн гүйцэтгэх
гүйцэтгэх захирал
Н.Хүрэлсүх
Нягтлан бодогч
М.Хулан
Төлбөр хариуцагч

“Цахилгаан тээвэр” ХХК-ийн
гүйцэтгэх захирал
Б.Жаргалсайхан



070327